



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 01 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 01 дүгээр хуралдааныг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар /2025-01-16/ Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, нэмэлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Харилцаа холбооны сүлжээний дугаар шинээр олгох, сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 11 (Тогтоол №01-11, 2025-01-16) тогтоолыг батлан шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, нэмэлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Харилцаа холбооны сүлжээний дугаар шинээр олгох, сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт, холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 12 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 11 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 3 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 03 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” /Хот, хот хоорондын ярианы үйлчилгээ эрхлэх суурин/) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 04 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 05 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 06 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах) сунгасан;
- Шуудангийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 10.1.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Илт смарт логистикс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 07 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд (Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 19 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 08 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 09 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 10 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдэд 5 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр тус тус сунгаж шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-01-21